

Эдийн засгийн огцом өсөлт бий боллоо

2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ оны үнээр 10,830 тэрбум төгрөг болж, эдийн засгийн өсөлт 17.3%-д хүрэв.


Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын өсөлт буурч байхад энэ нь олон улсын хэмжээнд хамгийн өндөр өсөлт байлаа. Уул уурхайн салбарт түшиглэсэн өсөлт, дэлхийн зах зээл дэх зэсийн өндөр үнэ, нүүрс болон төмрийн хүдрийн экспорт эрс нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дагуулж байна.



Улсын төсвийн зарлага эрс нэмэгдэв

Эдийн засаг эрчимтэй өсч, уул уурхайн салбараас төсөвт орох орлого нэмэгдсэнээр төсвийн тэлэлт бий болж байна.


2011 оны дүнгээр төсвийн орлого 33.2%, төсвийн зардал 55.6% тус тус өсч, төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 632 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. ДНБ-нд эзлэх төсвийн нийт зарлагын хувь 2010 онд 37% байсан бол энэ онд 44% болж өсчээ.



Гадаад худалдааны алдагдал 6 дахин өслөө

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2011 онд 11.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 85% өссөн байна. Импортын өсөлтийн хурд экспортын өсөлтийн хурдаас 1,6 дахин их байлаа.

Нүүрсний экспорт огцом нэмэгдсэн нь экспортын өсөлтөд голлон нөлөөлсөн бол импортын өсөлт нь уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой хүнд машин механизм, тоног төхөөрөмж болон нефть, тээврийн хэрэгслийн импортын өсөлтөөс шалтгаалсан байна.



Төгрөгийн ханш суларч байна

2011 онд төгрөгийн ам.долларт харьцах ханш 11.4% суларсан байна. Гадаад валютын дотогшлох урсгал нэмэгдсэн боловч эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор гарах урсгал нь илүү нэмэгдсэн учраас төгрөгийн ам.долларт харьцах ханш суларч байна.



Инфляцын түвшин 2 оронтой тоонд байсаар ...

Инфляцын жилийн түвшин энэ оны сүүлийн сарын байдлаар 10.2% байна.


Өмнөх жилтэй харьцуулахад тээвэр, орон сууц, хувцас, боловсролын үйлчилгээ, гэр ахуйн бараа, хүнсний барааны үнэ хамгийн их өссөн байна.



Эх сурвалж: ҮСХ, МБ

Мөнгөний нийлүүлэлт 37% нэмэгдэв

M2 мөнгө буюу мөнгөний нийлүүлэлт 2011 оны эцсээр 6.412 тэрбум төгрөгт хүрлээ. Үүнээс 11.1%-ийг гүйлгээнд байгаа бэлэн мөнгө эзэлж байна. Хөрөнгийн дотогшлох урсгалтай холбоотой мөнгөний нийлүүлэлтийн хурдацтай өсөлт бий болж байна.




Хадгаламж 41% өслөө

Төгрөгийн хадгаламж 46%, валютын хадгаламж 30% тус тус өссөн байна. Төрөөс хадгаламжид баталгаа гаргаж өгсөн нь энэ өсөлтөд нөлөөлсөн байна. Түүнчлэн хадгаламжийн өсөлт нь иргэдийн банкинд итгэх итгэл сайжирч буйг харуулж байна.



Зээл 73% нэмэгджээ

Мөнгөний нийлүүлэлтийн хурдацтай өсөлтийг даган зээл нэмэгдэж байна. Зээлийн чанар сайн байх буюу зээл эргэн төлөгдөж чадаж байх тусам бизнесийн байгууллагын хувьд үр өгөөжөө өгч байна гэсэн үг бөгөөд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь 2 дахин буурсан сайн үзүүлэлттэй байна.



Эх сурвалж: ҮСХ, МБ

2012 онд

Мөнгөний бодлого: МБ-ны зүгээс инфляцыг 2012 онд нэг оронтой тоонд барих бодлого баримтлахаа мэдэгдлээ.

Төсвийн тэлэх бодлого: Өнгөрсөн онтой харьцуулахад төсвийн орлого 40%, зарлага 32% өсч батлагдлаа.

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого – 5,826 тэрбум төгрөг
- Нэгдсэн төсвийн нийт зарлага - 6,309 тэрбум төгрөг
- Нэгдсэн төсвийн нийт алдагдал - 483 тэрбум төгрөг

Хураангуй

Монгол Улсын макро эдийн засгийн 2011 оны ерөнхий төлөв байдлыг харвал эдийн засгийн өсөлт хурдассан боловч төсвийн их хэмжээний тэлэлт, инфляцын өндөр түвшин, гадаад худалдааны их хэмжээний алдагдал, импортын хурдтай өсөлт бий болсон байна.

Энэ нь Монгол Улсын эдийн засагт хэт халалтын шинж тэмдэг илэрч буйг харуулж байна хэмээн олон улсын байгууллагууд анхааруулж байгаа бөгөөд ийм нөхцөл байдалд 2012 оны төсвийн тэлэх бодлого нь дотоодын эрэлтэнд дарамт учруулах, инфляцыг хөөрөгдөх аюул учруулж болзошгүй хэмээн сануулж байна.

Түүнчлэн Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан 2011 оны үр дүнгээр өрсөлдөх чадварын оноо нэмэгдэж 28 (100 онооноос) болсон боловч байр ухарч, харьцуулж буй 15 орны дундаас сүүл мушгижээ. Энэ нь манай улсын өрсөлдөх чадвар нэмэгдэж байгаа ч бусад оронтой харьцуулахад удаан байгааг харуулж байна.

Цаашид эдийн засгийн хэт халалтаас сэргийлсэн, эдийн засгийн мөчлөгтэй уялдсан бодлого баримтлах, эдийн засгийн сууриа бэхжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх, уул уурхайн олборлох салбараас олж буй орлогыг бусад капиталд хөрөнгө оруулалт хийн баялгийн өөр хэлбэрт шилжүүлэх, орлогын тэгш хуваарилалт, өсөлтийг жигд хүртээхэд анхаарах, боловсролын салбарт илүү хөрөнгө оруулах шаардлага тулгарч байна.